



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурал 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/40/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

(Хотын нэр оруулах)

2019 он

Тэргүүлэх аудитор:Ч.Ариунаа

Утас: Цахим хаяг:

Аудитын менежер:

Утас: Цахим хаяг:

Аудитор:Ц.Лүндэгмаа

Утас: Цахим хаяг:

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	
	Error! Bookmark not defined.	
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	10
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	12
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	13
2.11.	Шилэн дансны мэдээлэл	13
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	13
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	13
3	Менежментийн захидал	15
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	17

1 Аудитын гэрчилгээ



ЗАМЫН-ҮҮД СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
А.АНХТУЯА ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Замын-Үүд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Замын-Үүд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

1. Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан "Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал"-д байхгүй нэр төрөл болох Хурлын даргын нөөц хөрөнгийн зардал гэж 60.9 сая төгрөгийн төсөв баталсан.
2. Хурлын даргын нөөц хөрөнгөөс ИТХ-ын төлөөлөгчдийн тойрогт ажиллах зардал, оюутан сурагчдын сургалтын төлбөр болон биеийн тамирын уралдаан тэмцээнд оролцогчдод дэмжлэг, зочид төлөөлөгчдийг хүлээн авах зардал, байгууллагуудад хөрөнгийн дэмжлэг, шагнал урамшуулал, шинэ жилийн баяр зэрэгт нийт 59.9 сая төгрөгийн зардал гаргаж төсвийг үрэлгэн зарцуулсан.

Эдгээр нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг, хэмжилт гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Замын-Үүд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА



2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурал 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ИТХ-ын ажлын албаны дарга Анхтуяа -д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурал 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.25-наас 2019.03.01-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.03.04-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Лүндэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурал 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн

аудитын газарт 2019.02.25-ны өдөр /албан бичиггүй, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан/ ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурал талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурал “Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Монгол Улсын хуулиудад заагдсан эрх, үүргийн биелэлтийг ханган нутгийн өөрөө удирдах ёсны чадавхийг бэхжүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн байдалд төлөөлөгчдөөр дамжуулан иргэдийн хяналт, оролцоог дээшлүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн баталгааг бий болгох бодлого шийдвэрийг боловсруулан хэрэгжүүлэх, эхэлсэн ажлуудын тогтвортой байдлыг хангах” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурал үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Зорилт 1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны үйл ажиллагааг сумын хөгжлийн зорилтуудыг сайтар хэрэгжүүлэхэд чиглүүлэн хүртээмжтэй зохион байгуулан, хуралдааны шийдвэрийн хэрэгжилтийг хангуулна.

Зорилт 2. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны үйл ажиллагааг шуурхай хангаж, ИТХ-д хуулиар олгогдсон бүрэн эрх, үүргийн хүрээнд орон нутаг болон иргэдийн ашиг сонирхолд нийцүүлсэн бодлого боловсруулж оновчтой шийдвэр гарган ажиллана.

Зорилт 3. Төлөөлөгч, хурлын хороодыг идэвжжүүлэн Хуралд хуулиар олгогдсон хяналт шалгалтын ажлын үр дүнг дээшлүүлэн хуулийн хэрэгжилт, сумын эдийн засгийн чадавхыг сайжруулахад нөлөөлж ажиллана.

Зорилт 4. Хурлын төлөөллийн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ төлөөлөгч-иргэдийн хамтын ажиллагааг сайжруулах замаар иргэдийн идэвх оролцоог дээшлүүлнэ.

Зорилт 5. ИТХ-ын үйл ажиллагаа, гарсан шийдвэрийг олон нийтэд шуурхай хүргэж, тэмдэглэлт өдөр, хууль тогтоомжийг сурталчлах нөлөөллийн ажлуудыг хийн Хурал, иргэдийн хамтын ажиллагааг сайжруулна.

Зорилт 6. Хурлын ажлын албаны шуурхай байдлыг ханган нутгийн өөрөө удирдах байгууллагыг бэхжүүлэхэд шаардагдах ажлыг зохион байгуулна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурал үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурал удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурал санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй

байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурал санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “aculous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурал дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Их гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурал бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт зардал*-ын 2 хувиар сонгов.

Нийт зардал-г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тус байгууллага орон нутгийн төсвийн санхүүжилтээр үйл ажиллагааг хэрэгжүүлдэг учраас санхүүжилтийг хэр үр ашигтай байгааг тодруулах зорилготойгоор нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгож авсантай холбоотой юм.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурал 2018 оны *Нийт зардал* 174969.8.40 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 3,499.40 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 41 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцлоо.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	11400.0	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	751.0	
3	Албан шаардлага өгсөн	3	76571.7	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	1	18400.0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	6	107122.7	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

- 3-р цэцэрлэгийн төв хаалганд үүдний таамбар хийхэд зарцуулагдах төсөв хөрөнгө шийдвэрлэх гэрээг 2-р тойргийн төлөөлөгч Г.Баттөр, хүүхдийн 3-р цэцэрлэгийн эрхлэгч И. Ган-Эрдэнэ нар байгуулсан бөгөөд тус гэрээний 1.2 дахь заалтад “3.0 сая төгрөгийн санхүүжилтэд багтаан хийх” гэж тусгасан байна. Гэтэл ИТХ-ын төлөөлөгчдийн 2-р тойрогт ажиллах зардлын төсвөөс 3751.0 мянган төгрөг шилжүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг зөрчсөн тул 2-р цэцэрлэгээр 751.0 мянган төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоов.
- Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”-д байхгүй нэр төрөл болох Хурлын даргын нөөц хөрөнгийн зардал гэж 60959.7 мянган төгрөгийн төсөв баталсан.

Сумын ИТХ-ын даргын нөөц хөрөнгийг зарцуулах журам, Сумын ИТХ-ын төлөөлөгчид тойрогтоо ажиллахад хөрөнгө зарцуулах журам гаргасан ба Хурлын даргын нөөц хөрөнгөөс ИТХ-ын төлөөлөгчдийн тойрогт ажиллах зардал, оюутан сурагчдын сургалтын төлбөр болон биеийн тамирын уралдаан тэмцээнд оролцогчдод дэмжлэг, зочид төлөөлөгчдийг хүлээн авах зардал, байгууллагуудад хөрөнгийн дэмжлэг, шагнал урамшуулал, шинэ жилийн баяр зэрэгт нийт 59951.7 мянган төгрөгийн зардал гаргаж төсвийг үрэлгэн зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна. Мөн Сангийн

сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан зардлын зориулалт болон арга хэмжээний ангилалд ИТХ-ын даргын нөөц хөрөнгө гэсэн ангилал байхгүй, 81102 гэсэн ангилагдаагүй нөөцийн зориулалтад “Орон нутгийн нөөц хөрөнгө” гэж заасан байна. Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар”-т Орон нутгийн нөөц хөрөнгийг “Орон нутгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд зарцуулагдах нөөц хөрөнгийг энэ ангилалд бүртгэн төлөвлөлт гүйцэтгэлийг хуулийн дагуу зарцуулагдах зориулалтаар гаргана” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд эдгээр зөрчлийг таслан зогсоож сумын ИТХ-ын даргын нөөц хөрөнгийн зардлын төсөв батлахгүй байх, сумын ИТХ-аас баталсан ИТХ-ын даргын нөөц хөрөнгийн зардлын 2019 оны /30.0 сая төгрөгийн/ төсвөөс зарлагын гүйлгээ гаргахгүй байх гэсэн албан шаардлага өгөв.

3. ИТХ-ын төлөөлөгчдийн 1-р тойрогт ажиллах зардлаас иргэн Ц.Долгортой тоглоомын талбайд 4.7 сая төгрөгөөр хүүхдийн тоглоом, сүүдрэвч барих гэрээ байгуулж 2018 оны 8 сарын 01-ний өдрөөс 2019 оны 5 сарын 1 хүртэлх хугацаанд гүйцэтгэхээр тусгасан ба мөнгийг 2018 оны 12 сарын 07-ны өдөр бүрэн шилжүүлсэн байна. Уг тоглоомын талбайг хүлээн авсан акт байхгүй байна.

ИТХ-ын төлөөлөгчдийн 2-р тойрогт ажиллах зардлаас иргэн Г.Баттөрөөс 520.0 мянган төгрөгөөр сагсан бөмбөгийн шит авсан гэх боловч суурилуулсныг нотлох баримтгүй, хүлээн авсан акт байхгүй байна.

ИТХ-ын төлөөлөгчийн 4-р тойрогт ажиллах зардлаас Чандмань бадрал ХХК-аар Сүлд багийн 11-р хэсгийн гадна шугам сүлжээний 6.7 сая төгрөгийн ажил гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан. Гэрээнд ажил дуусах хугацаа тодорхойгүй, тус ажлыг хүлээн авсан акт байхгүй байна. 2018 оны 12 сарын 5-ны өдөр 6.7 сая төгрөгийг Чандмань бадрал ХХК-д бүрэн шилжүүлсэн байна.

Энэ нь Иргэний тухай хуулийн 343.2-т “Ажил гүйцэтгэх гэрээний зүйл нь гүйцэтгэсэн ажлын үр дүн байна”, 343.3-т “Ажил гүйцэтгэгч ямар нэгэн эд зүйлийг хийсэн бол түүнийг захиалагчийн өмчлөлд шилжүүлнэ” гэж заасныг тус тус зөрчсөн байна. Иргэн Ц.Долгор, иргэн Г.Баттөр болон Чандмань бадрал ХХК-ны гэрээний дагуу гүйцэтгэх ажлуудыг бүрэн дуусгуулж 11920.0 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч, холбогдох газруудын данс бүртгэлд тусгуулах албан шаардлага өгөв.

4. Тус байгууллага жилийн эцсийн дүнгээр 4700.0 мянган төгрөгийн үнэ бүхий бараа материалын үлдэгдэлд хийсэн тооллогыг хуулийн хүрээнд зохион байгуулаагүй, ЗДТГ,ЗАА,ИТХ-ын хөрөнгийг нийлүүлж тоолсон зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70-ын 2/ "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/ хийнэ", мөн хуулийн 71, 72 дугаар зүйлд заасны дагуу хөрөнгийн тооллого хийхийн өмнө бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгаж өмнөх тооллогоор тайлан тэнцлээс хасахаар шийдвэрлэсэн үндсэн хөрөнгө, түүхий эд материал, барааг худалдах, устгах зэргээр бүрэн шийдвэрлүүлж үр дүнг бүртгэлд тусгасан байх;

Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгч эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнийн жишгээс хэт өндөр үнээр авсан, хэт доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгө, түүхий эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас хасуулах тухай саналаа тавих гэсэн заалтуудтай нийцэхгүй байна. Иймд байгууллагын үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийг хуулийн хүрээнд зохион байгуулах албан шаардлага өгөв.

5. Өмнөх онд аудитаар 18400.0 мянган төгрөгийн зөрчилд өгсөн "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, эдийн засгийн ангилал тус бүрээр ажил гүйлгээг бүртгэж байх, оюутны тэтгэлэгт хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг баримтжуулж гэрээний биелэлтэд хяналт тавих, бараа материалыг тайлант хугацаанд үнэн зөв тайлагнах" зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан "Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал"-д байхгүй нэр төрөл болох Хурлын даргын нөөц хөрөнгийн зардал гэж 70.0 сая төгрөгийн төсөв баталсан. Хурлын даргын нөөц хөрөнгөөс ИТХ-ын төлөөлөгчдийн тойрогт ажиллах зардал, оюутан сурагчдын сургалтын төлбөр болон биеийн тамирын уралдаан тэмцээнд оролцогчдод дэмжлэг, зочид төлөөлөгчдийг хүлээн авах зардал, байгууллагуудад хөрөнгийн дэмжлэг, шагнал урамшуулал, шинэ жилийн баяр зэрэгт нийт 60.9 сая төгрөгийн зардал гаргаж төсвийг үрэлгэн зарцуулсан гэсэн үндэслэлээр тус байгууллагын 2018 оны санхүүгийн тайланд "Хязгаарлалттай" дүгнэлт өгч байгаа тул Замын-Үүд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны дарга А.Анхтуяад сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага хүргүүлээ.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

ИТХ-ын 00-03 улсын дугаартай Ланд-200 авто машинд 2017 онд 12.2 сая төгрөгийн, 2018 онд 12.7 сая төгрөгийн урсгал засварын зардал хийгдсэн байна. Авто машины хувийн хэргийн хөтлөлт, сэлбэг хэрэгслийн норм, нормативыг үзэх, мөн барилгын материал 2017, 2018 оны эцэст 1.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсаныг эд хариуцагчийн тайлан болон тооллогын бүртгэлтэй тулгаж үзэх нь зүйтэй.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурал чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2 хөтөлбөр, 5 арга хэмжээнд зориулан 2018 онд 136890.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан ба 2018 оны 12 сард үндсэн үйл ажиллагааны төсвийг 9.0 сая төгрөгөөр, ангилагдаагүй бусад зориулалт арга хэмжээг 4.9 сая төгрөгөөр, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг 1.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, сахилга хариуцлага, үр дүнгийн урамшуулал гэсэн зардлын төсвийг 1.2 сая төгрөгөөр бууруулж, анхны төсвийг нийт 14.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн өөрчлөлт оруулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 146969.6 мянган төгрөг буюу 97.2 хувьтай байгаа нь урсгал зардлыг хэмнэж 4187.6 мянган төгрөгийг төвлөрүүлснээс шалтгаалжээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурал Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 75 хувьтай байна.

“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, эдийн засгийн ангилал тус бүрээр ажил гүйлгээг бүртгэж байх, оюутны тэтгэлэгт хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг баримтжуулж тайлагнах, гэрээний биелэлтэд хяналт тавих” гэсэн зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурал 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурал 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурал нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

3.1.1. Илрүүлэлт: Авлага

Тайлант жилийн эцэст Чандмань бадрал ХХК-ийн нягтлан бодогчтой 11-р хэсгийн гадна шугам сүлжээний ажлын төлбөрийн тооцоо нийлж ИТХ 6700.0 мянган төгрөгийн илүү төлөлттэй гэсэн тооцоо нийлсэн акт үйлдсэн боловч санхүүгийн тайланд авлага үүсгэн бүртгээгүй байна. Мөн иргэн Ц.Долгорт 4700.0 мянган төгрөг шилжүүлээд ажил хүлээж аваагүй байхад санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1. “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө. 3.1.1. “нягтлан бодох бүртгэлийн аккрузал суурь” гэж мөнгө хүлээн авсан, эсхүл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг”, 14.4.2. “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ.” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.1.2. Эрсдэл: Төсвийг үр ашиггүй зүйлд зарцуулах, үнэн зөв байх, оршин байх гэсэн батламж мэдэгдэл хангагдахгүй байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.1.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1 дэх заалтыг хэрэгжүүлж нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар бүртгэж тайлагнах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 сарын 5-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,776,388.41</u>	<u>4,704,100.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
33	АВЛАГА	91,988.41	00.00
335	Бусад авлага	91,988.41	00.00
3351	Байгууллагаас авах авлага	91,988.41	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	3,684,400.00	4,704,100.00
351	Түүхий эд материал	00.00	00.00
354	Хангамжийн материал	3,684,400.00	4,704,100.00
35410	Бичиг хэргийн материал	106,600.00	648,300.00
35420	Аж ахуйн материал	1,657,050.00	1,657,050.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	478,000.00
35450	Барилгын засварын материал	1,920,750.00	1,920,750.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>62,893,014.49</u>	<u>46,548,724.61</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	62,893,014.49	46,548,724.61
391	Газар	00.00	00.00
392	Биет хөрөнгө	62,893,014.49	46,548,724.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	26,552,630.00	26,552,630.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-5,059,298.78	-5,501,842.58
39203	Авто-тээврийн хэрэгсэл	75,000,000.00	75,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-47,395,833.47	-59,895,833.51
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	13,830,173.00	13,830,173.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-5,471,772.70	-7,567,652.82
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,252,109.00	11,252,109.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,814,992.56	-7,120,858.48
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>66,669,402.90</u>	<u>51,252,824.61</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>30,576.62</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	30,576.62
413	Өглөг	00.00	30,576.62
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		30,576.62
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>66,669,402.90</u>	<u>51,222,247.99</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	66,669,402.90	51,222,247.99
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	45,528,852.86	45,528,852.86
512	Хуримтлагдсан үр дүн	8,496,644.04	-6,950,510.87
51210	Өмнөх үеийн үр дүн	8,496,644.04	8,496,644.04
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-15,447,154.91
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	12,643,906.00	12,643,906.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>66,669,402.90</u>	<u>51,252,824.61</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	62,426,800.00	159,522,685.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	8,365,385.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	8,365,385.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	8,365,385.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	7,886,185.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	00.00	00.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	00.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	479,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	62,426,800.00	151,157,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	61,426,800.00	151,157,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61,426,800.00	151,157,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	56,228,873.92	174,969,839.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	56,228,873.92	174,969,839.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	56,228,873.92	170,782,195.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,092,602.00	53,763,430.06
210101	Үндсэн цалин	22,092,602.00	53,763,430.06
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,100,916.00	6,382,113.01
210201	Тэтгэврийн даатгал	1,373,056.00	4,287,627.02
210202	Тэтгэмжийн даатгал	90,998.00	535,952.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	181,983.00	413,762.39
210204	Ажилгүйдлийн даатгал	90,998.00	102,759.61
210205	Эрүүл мэндийн даатгал	363,881.00	1,042,011.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,125,587.00	10,072,915.30
210401	Бичиг хэрэг	241,500.00	3,753,900.00
210402	Тээвэр, шатахуун	1,694,000.00	3,276,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	190,087.00	527,015.30
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	2,516,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,088,666.00	12,700,000.00
210604	Урсгал засвар	10,088,666.00	12,700,000.00
2107	Томилолт, зочны зардал	421,400.00	1,716,300.00
210702	Дотоод албан томилолт	421,400.00	676,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	1,040,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,588,431.00	69,803,147.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,588,431.00	69,628,747.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	59,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	93,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	22,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,811,271.92	16,344,289.88

Замын-Үүд сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,340,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,471,271.92	16,344,289.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	4,187,644.66
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	4,187,644.66
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	6,197,926.08	-15,447,154.91
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	6,197,926.08	-15,447,154.91

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	62,426,800.00	159,043,485.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	7,886,185.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	7,886,185.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	7,886,185.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	7,886,185.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	62,426,800.00	151,157,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,000,000.00	00.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	61,426,800.00	151,157,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61,426,800.00	151,157,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	50,222,899.00	159,043,485.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	50,222,899.00	159,043,485.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	50,222,899.00	154,855,840.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,504,899.00	53,640,865.03
210101	Үндсэн цалин	22,504,899.00	53,640,865.03
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,100,916.00	6,382,113.01
210201	Тэтгэврийн даатгал	1,373,056.00	4,287,627.02
210202	Тэтгэмжийн даатгал	90,998.00	535,952.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	181,983.00	413,762.39
210204	Ажилгүйдлийн даатгал	90,998.00	102,759.61
210205	Эрүүл мэндийн даатгал	363,881.00	1,042,011.99
2104	Хангамж, бараа материалын зардал	2,003,587.00	5,413,115.30
210401	Бичиг хэрэг	241,500.00	1,192,100.00
210402	Тээвэр, шатахуун	1,572,000.00	3,694,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	190,087.00	527,015.30
2105	Нормативт зардал	1,000,000.00	00.00
210502	Хоол, хүнс	1,000,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,088,666.00	12,396,800.00
210604	Урсгал засвар	10,088,666.00	12,396,800.00

2107	Томилолт, зочны зардал	421,400.00	1,716,300.00
210702	Дотоод албан томилолт	421,400.00	676,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	1,040,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,763,431.00	75,306,647.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,763,431.00	75,132,247.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	59,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	93,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	22,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,340,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,340,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	4,187,644.66
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	4,187,644.66
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>12,203,901.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	12,203,901.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,203,901.00	00.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	45,528,852.86	12,670,950.00	18,171,354.76	76,371,157.62
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	45,528,852.86	12,670,950.00	18,171,354.76	76,371,157.62
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-6,587,342.70	-6,587,342.70
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	45,528,852.86	12,643,906.00	8,496,644.04	66,669,402.90
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	45,528,852.86	12,643,906.00	8,496,644.04	66,669,402.90
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-15,447,154.91	-15,447,154.91
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	45,528,852.86	12,643,906.00	-6,950,510.87	51,222,247.99

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	00.00	00.00	151,157,300.00	146,969,655.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	00.00	00.00	151,157,300.00	146,969,655.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00	00.00	151,157,300.00	146,969,655.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00.00	00.00	54,521,700.00	53,640,865.03
210101	Үндсэн цалин	00.00	00.00	54,521,700.00	53,640,865.03
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	00.00	00.00	6,542,600.00	6,382,113.01
210201	Тэтгэврийн даатгал	00.00	00.00	4,361,700.00	4,287,627.02
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	00.00	545,200.00	535,952.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00	436,100.00	413,762.39
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00	109,000.00	102,759.61
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	1,090,600.00	1,042,011.99
2104	Хангамж, бараа материалын зардал	00.00	00.00	6,036,500.00	5,413,115.30
210401	Бичиг хэрэг	00.00	00.00	1,200,000.00	1,192,100.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	00.00	3,696,500.00	3,694,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	00.00	1,140,000.00	527,015.30
210404	Ном, хэвлэл	00.00	00.00	00.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	00.00	12,426,800.00	12,396,800.00
210604	Урсгал засвар	00.00	00.00	12,426,800.00	12,396,800.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	00.00	2,243,800.00	1,716,300.00
210702	Дотоод албан томилолт	00.00	00.00	1,203,500.00	676,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00	1,040,300.00	1,040,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	00.00	69,385,900.00	67,420,462.00

Замын-Үүд сумын ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	00.00	69,094,000.00	67,246,062.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	00.00	176,900.00	59,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	00.00	93,000.00	93,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	00.00	22,000.00	22,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	00.00	00.00	151,157,300.00	151,157,300.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	151,157,300.00	151,157,300.00
132001	Орон нутгийн төсвөөс	00.00	00.00	151,157,300.00	151,157,300.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	00.00	00.00	00.00	00.00
610001	Төсвийн байгууллага	00.00	00.00	00.00	00.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	00.00	00.00	1,020.00	05.00
620001	Удирдах ажилтан	00.00	00.00	555.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	00.00	00.00	455.00	02.00
620003	Үйлчлэх ажилтан	00.00	00.00	10.00	01.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00	00.00	01.00